



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/88/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай хот 2024 он</p>	<p>Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-undraaD@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Баасанжаргал Утас: 99032514 Цахим хаяг: BaasanjargalG@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.5.3 Нэмэлт төсөв	14
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	14
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.23 № 163

танай _____-ны № _____-т

УЛИАСТАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Т.МӨНХБААТАР-Т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу сумын Улиастай Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Улиастай сумын Засаг даргын Тамгын газар нь сумын 6 багийн ахмадуудын хүлээн авалт зохион байгуулахдаа төсвөөс гарын бэлэг, дурсгалын зүйлс, хоол хүнсний материал худалдан авч 53,993,600 төгрөгийн зориулалт бус зардал гаргасан, албан хаагчдад 825,000 төгрөгөөр ажлын хувцас худалдан авсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" зэрэг заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Улиастай сумын Засаг даргын Тамгын газар нь эрх бүхий байгууллагын шийдвэргүй 108,185,000 төгрөгийн нийтийн тээврийн автобус, 10,900,000 төгрөгийн мотоцикл худалдан авсан байна. Тайлант онд үнэ төлбөргүй 286,736,050 төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний

тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар тайланд тусгагдаагүй урьд онуудын өр төлбөр 5,915,850 төгрөгийг шилжүүлсэн, газрын нэгдсэн системд бүртгэлтэй газруудыг данс бүртгэлд бүрэн тусгаагүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Улиастай сумын Засаг даргын Тамгын газар нь байгууллагад төлөх хүнсний материалын 5,000,000 төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй, 13,210,000 төгрөгөөр худалдан авсан модны суулгацыг санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй, үнэ төлбөргүй нэмэгдсэн хяналт, шинжилгээ үнэлгээний 4,500,000 төгрөгийн программ, 108,185,000 төгрөгийн автобусыг данс бүртгэлд тусгаагүй, 5,000,000 төгрөгөөр худалдан авсан өвс тэжээлийг бараа материал дансанд орлого аваагүй зэрэг алдаа гаргасныг аудитын явцад залруулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д. БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>/ төгрөгөөр /</i>			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	69,940,389.47	105,507,809.30
33	АВЛАГА	676,422.17	13,210,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	676,422.17	0
33500	Бусад авлага	0	13,210,000.00
33510	Байгууллагаас авах авлага	0	13,210,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	69,263,967.30	92,297,809.30
35100	Түүхий эд материал	2,000,000.00	2,003,000.00
35110	Тусгай зориулалттай материал	0	3,000.00
35130	Эм боох материал	2,000,000.00	2,000,000.00
35400	Хангамжийн материал	67,263,967.30	90,294,809.30
35410	Бичиг хэргийн материал	2,764,290.00	4,508,030.00
35420	Аж ахуйн материал	55,124,677.30	65,034,317.30
35430	Сэлбэг хэрэгсэл	6,496,000.00	7,206,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,980,000.00	8,284,512.00
35450	Барилгын засварын материал	899,000.00	899,000.00
35470	Бусад хангамжийн материал	0	4,362,950.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,944,397,088.99	2,210,893,762.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,944,397,088.99	2,210,893,762.00
39200	Биет хөрөнгө	1,924,103,588.99	2,186,680,262.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,286,610,548.00	2,466,110,548.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-622,649,972.57	-694,939,248.89
39203	Авто-тээврийн хэрэгсэл	229,899,000.00	411,134,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-155,732,333.57	-195,021,917.04
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	111,634,863.60	129,064,663.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-38,540,127.84	-60,418,745.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,013,329.85	48,013,329.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	-45,075,118.66	-46,162,018.42
39214	Бусад үндсэн хөрөнгө	151,409,000.00	174,565,250.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-41,465,599.82	-45,665,599.82
39300	Биет бус хөрөнгө	20,293,500.00	24,213,499.92
39301	Програм хангамж	2,862,000.00	7,362,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,064,500.00	-2,644,500.08
39303	Бусад биет бус хөрөнгө	19,496,000.00	19,496,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,014,337,478.46	2,316,401,571.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	260,600.00	5,000,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	260,600.00	5,000,000.00
41300	Өглөг	260,600.00	5,000,000.00
41360	Бусад өглөг	260,600.00	5,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	260,600.00	5,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,014,076,878.46	2,311,401,571.30
51	Засгийн газрын хувь оролцоо	2,014,076,878.46	2,311,401,571.30
51100	Засгийн газрын оруулсан капитал	317,322,275.75	317,322,275.75
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	317,322,275.75	317,322,275.75
51200	Хуримтлагдсан үр дүн	1,350,559,679.87	1,647,884,372.71
51210	Өмнөх үеийн үр дүн	1,323,970,702.02	1,350,559,679.87
51220	Тайлант үеийн үр дүн	26,588,977.85	297,324,692.84
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0	0

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	346,194,922.84	346,194,922.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,014,337,478.46	2,316,401,571.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

<i>/ төгрөгөөр /</i>			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,390,909,902.00	3,504,510,612.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,861,300.00	271,270,388.67
120	Нийтлэг татварын бус орлого	52,861,300.00	271,270,388.67
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	52,383,250.00	271,247,966.67
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	52,383,250.00	271,247,966.67
120009	Бусад орлого	478,050.00	22,422.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,338,048,602.00	3,233,240,223.92
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	723,912,602.00	3,233,240,223.92
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	723,912,602.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	3,233,240,223.92
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	614,136,000.00	0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	614,136,000.00	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,364,320,924.15	4,541,103,244.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,364,320,924.15	4,541,103,244.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,308,386,573.36	4,456,938,711.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	589,536,720.19	919,140,971.64
210101	Үндсэн цалин	473,630,145.81	596,176,117.44
210102	Нэмэгдэл	78,771,570.60	220,038,020.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	38,175,332.79
210104	Урамшуулал	37,135,003.78	64,751,501.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,330,200.00	115,230,100.00
210201	Тэтгэврийн даатгал	50,679,547.95	78,356,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,579,265.20	9,218,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,512,112.06	7,374,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	878,053.07	1,843,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,681,221.72	18,436,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,291,299.40	115,706,653.21
210301	Гэрэл, цахилгаан	11,632,224.40	25,310,862.71
210302	Түлш, халаалт	85,365,435.00	86,108,780.50
210303	Цэвэр, бохир ус	3,293,640.00	4,287,010.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,237,321.45	56,070,139.30
210401	Бичиг хэрэг	7,678,089.00	7,413,320.00
210402	Тээвэр, шатахуун	24,790,896.00	36,007,288.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,768,336.45	12,649,531.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,832,950.00	11,619,830.00
210604	Урсгал засвар	2,832,950.00	11,619,830.00
2107	Томилолт, зочны зардал	2,263,800.00	4,527,700.00
210702	Дотоод албан томилолт	2,263,800.00	4,527,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,972,864.00	10,210,143.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,027,022.00	8,962,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	469,000.00	250,860.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,742.00	195,748.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,800.00	64,590.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	68,000.00	600,400.00
210807	Газрын төлбөр	138,300.00	135,845.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	456,921,418.32	3,224,433,174.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	349,081,384.00	3,111,953,381.17
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	325,300.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	107,514,734.32	112,479,793.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,934,350.79	84,164,533.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	17,460,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	17,460,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	54,434,350.79	66,703,633.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,037,971.87	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	44,396,378.92	66,703,633.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	26,588,977.85	-1,036,592,632.39
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	26,588,977.85	-1,036,592,632.39

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,338,526,652.00	3,232,362,645.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	478,050.00	0
120	Нийтлэг татварын бус орлого	478,050.00	0
120009	Бусад орлого	478,050.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,338,048,602.00	3,232,362,645.92
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	723,912,602.00	3,232,362,645.92

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	723,912,602.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	3,232,362,645.92
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	614,136,000.00	0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	614,136,000.00	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,257,126,652.00	4,447,194,971.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,257,126,652.00	4,447,194,971.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,201,192,301.21	4,363,030,438.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	589,536,720.19	919,140,971.64
210101	Үндсэн цалин	473,630,145.81	596,176,117.44
210102	Нэмэгдэл	78,771,570.60	220,038,020.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	38,175,332.79
210104	Урамшуулал	37,135,003.78	64,751,501.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,330,200.00	115,230,100.00
210201	Тэтгэврийн даатгал	50,679,547.95	78,356,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,579,265.20	9,218,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,512,112.06	7,374,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	878,053.07	1,843,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,681,221.72	18,436,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,291,299.40	115,865,953.21
210301	Гэрэл, цахилгаан	11,632,224.40	12,688,362.71
210302	Түлш, халаалт	85,365,435.00	98,731,280.50
210303	Цэвэр, бохир ус	3,293,640.00	4,446,310.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,718,582.45	63,701,731.30
210401	Бичиг хэрэг	7,226,650.00	8,740,400.00
210402	Тээвэр, шатахуун	26,723,596.00	42,311,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,768,336.45	12,649,531.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,967,300.00	14,027,800.00
210604	Урсгал засвар	2,967,300.00	14,027,800.00
2107	Томилолт, зочны зардал	2,263,800.00	4,527,700.00
210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	2,263,800.00	4,527,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,205,542.00	11,520,605.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,970,900.00	10,241,210.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,800.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	469,000.00	250,860.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,742.00	227,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,800.00	64,590.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	68,000.00	600,400.00
210807	Газрын төлбөр	138,300.00	135,845.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	354,878,857.17	3,119,015,577.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	354,575,457.17	3,118,712,177.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,934,350.79	84,164,533.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	17,460,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	17,460,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	54,434,350.79	66,703,633.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,037,971.87	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	44,396,378.92	66,703,633.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	81,400,000.00	-1,214,832,325.23
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	81,400,000.00	119,085,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	81,400,000.00	119,085,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	81,400,000.00	119,085,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	81,400,000.00	119,085,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-81,400,000.00	-119,085,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	-1,333,917,325.23

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

<i>/ төгрөгөөр /</i>					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	317,322,275.75	346,194,922.84	1,323,970,702.02	1,987,487,900.61
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	317,322,275.75	346,194,922.84	1,350,559,679.87	2,014,076,878.46
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	317,322,275.75	346,194,922.84	1,323,970,702.02	1,987,487,900.61
9	Тайлант үеийн үр дүн	0	0	26,588,977.85	26,588,977.85
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	317,322,275.75	346,194,922.84	1,350,559,679.87	2,014,076,878.46

20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	317,322,275.75	346,194,922.84	1,647,884,372.71	2,311,401,571.30
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	317,322,275.75	346,194,922.84	1,350,559,679.87	2,014,076,878.46
19	Тайлант үеийн үр дүн	0	0	297,324,692.84	297,324,692.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,338,780,600.00	1,333,917,325.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,338,780,600.00	1,333,917,325.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,321,319,700.00	1,316,456,425.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	921,839,700.00	919,140,971.64
210101	Үндсэн цалин	666,261,700.00	596,176,117.44
210102	Нэмэгдэл	255,578,000.00	220,038,020.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	38,175,332.79
210104	Урамшуулал	0	64,751,501.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,230,100.00	115,230,100.00
210201	Тэтгэврийн даатгал	78,356,400.00	78,356,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,218,400.00	9,218,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,374,800.00	7,374,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,843,700.00	1,843,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,436,800.00	18,436,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,021,000.00	115,865,953.21
210301	Гэрэл, цахилгаан	13,362,200.00	12,688,362.71
210302	Түлш, халаалт	98,508,800.00	98,731,280.50
210303	Цэвэр, бохир ус	4,150,000.00	4,446,310.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,234,700.00	49,181,195.38
210401	Бичиг хэрэг	8,740,400.00	8,740,400.00
210402	Тээвэр, шатахуун	29,394,900.00	29,358,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,099,400.00	11,082,195.38
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,027,800.00	14,027,800.00
210604	Урсгал засвар	14,027,800.00	14,027,800.00
2107	Томилолт, зочны зардал	4,527,700.00	4,527,700.00
210702	Дотоод албан томилолт	4,527,700.00	4,527,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,079,600.00	11,123,605.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,258,000.00	10,241,210.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	693,600.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	250,860.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	227,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,800.00	64,590.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	203,400.00
210807	Газрын төлбөр	138,300.00	135,845.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15,700.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,359,100.00	87,359,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,055,700.00	87,055,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,460,900.00	17,460,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,460,900.00	17,460,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,460,900.00	17,460,900.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,338,780,600.00	1,333,917,325.23
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,245,022,600.00	1,333,917,325.23
320001	Орон нутгийн төсвөөс	1,245,022,600.00	1,333,917,325.23
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	93,758,000.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	93,758,000.00	0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	109	109
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	54	54
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	22	22
620003	Үйлчлэх ажилтан	2	2
620004	Гэрээт ажилтан	21	21
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	54	54
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	21	21
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	4
650010	Гэрээт ажилтан	21	21
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,232,362,645.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,232,362,645.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,165,659,012.92
210304	Байрны түрээс	0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,520,535.92
210402	Тээвэр, шатахуун	12,953,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,567,335.92
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	397,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	397,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,150,741,477.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,150,741,477.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,703,633.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	66,703,633.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	66,703,633.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,232,362,645.92
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,232,362,645.92
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,232,362,645.92

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улиастай сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах төрийн байгууллага, мэргэжилтэн, албан хаагч багийн Засаг дарга нарын ажлыг уялдуулан оновчтой бодлого, зохицуулалтаар хангаж орон нутгийн хөгжлийн төлөө төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэж, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэхэд чиглэгдэнэ.

Тус байгууллага нь “Төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай, ил тод, шударга, хүртээмжтэй хүргэх” гэсэн зорилгын хүрээнд 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 69 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлт 95.6 хувьтай үнэлэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улиастай сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Шилэн дансны тухай, Хөдөлмөрийн тухай, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөхөөс гадна Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам бусад хууль, тогтоомж, журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит болон аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 302,064.1 мянган төгрөгөөр буюу 13 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	676.4	13,210.0	12,533.6
Бараа материал	69,264.0	92,297.8	23,033.8
Үндсэн хөрөнгө	1,944,397.1	2,210,893.8	266,496.7
Нийт хөрөнгө	2,014,337.5	2,316,401.6	302,064.1
Өр төлбөр	260.6	5,000.0	4,739.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,014,076.8	2,311,401.5	297,324.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,014,337.4	2,316,401.5	302,064.1

Дээрх хүснэгтээс харахад бараа материал, үндсэн хөрөнгө дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Бараа материалын эхний үлдэгдэл 69,264.0 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 71,662.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 12,256.5 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 60,884.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 92,297.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 23,033.9 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 405,821.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, жилийн эцэст 3,255,745.8 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны элэгдлийн зардалд 112,479.8 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 297,324.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 1,097,027.7 мянган төгрөгөөр тоцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 50,000.0 мянган төгрөгөөр бууруулж, нийт 1,047,027.7 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 197,994.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн үндсэн болон баг хороо, мэдээлэл сурталчилгаа, орон нутгийн нөөц хөрөнгө зэрэг 6 үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр 1,245,022.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,338,780.6 мянган төгрөгийн санхүүжилт, олгож, гүйцэтгэл 1,333,917.3 мянган төгрөг буюу 99.6 хувьтай бөгөөд үйл ажиллагааны орлого 4,863.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Код	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	628,678.1	672,436.1	-43,758.0	107.0
2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил	341,909.8	341,909.8	0.0	0.0
3	80106	Баг хорооны үйл ажиллагааны зардал	231,135.8	231,135.8	0.0	100.0
4	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	1,200.0	1,200.0	0.0	0.0
5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	17,460.9	17,460.9	0.0	0.0
6	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	50,000.0	55,000.0	-5,000.0	110.0
7	81701	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	19,638.0	19,638.0	0.0	100.0
		Дүн	1,290,022.6	1,338,780.6	-48,758.0	103.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр нийт 3,232,340.2 мянган төгрөгийн орлого орсон бөгөөд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 967,879.9 мянган төгрөг, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1,881,864.2 мянган төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газраас 54,000.0 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс 1,704.4 мянган төгрөг, өөрийн орлого 282,495.3 мянган төгрөг, 2022 оны үлдэгдэл 44,396.4 мянган төгрөг зэргээс бүрдсэн байна. Үүнийг аймгаас эрх шилжиж хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлууд, ахмадын баяр, шатахуун болон бусад зардлуудад зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас 66,703.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, төсөл хөтөлбөр гараагүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих төсөвт өртөг	Шалгаруулалтын арга
1	Улиастай сумын хот тохижилт, үйлчилгээний албанд хогны машин авах	80,000.00	79,800.00	Харьцуулалтын арга
2	Улиастай сумын гудамжны гэрэлтүүлгийн засвар хийх	50,000.00	49,950.00	Харьцуулалтын арга
3	Улиастай суманд City toilet байгуулах	80,000.00	79,996.66	Харьцуулалтын арга
4	Нутгийн удирдлагын ордны зүүн талын зогсоолыг засварлах	80,000.00	79,536.60	Харьцуулалтын арга
5	Улиастай сумын 4-р цэцэрлэгийн дээврийн засвар хийх	100,000.00	94,576.64	Харьцуулалтын арга
6	Улиастай сумын төв гудамж дагуух барилгуудын гадна талбайг тохижуулж, гоёлын гэрэлтүүлэг хийх	100,000.00	97,316.57	Харьцуулалтын арга
7	Улиастай сумын Богдын гол багт явган хүний зам байгуулах	230,600.00	225,020.42	Нээлттэй тендер шалгаруулалт
8	Улиастай сумын 1-р сургуулийн 80 хүүхдийн дотуур байрны ариун цэврийн өрөөг засварлах	35,000.00	33,452.24	Харьцуулалтын арга
9	Улиастай сумын нийтийн эзэмшлийн зам талбайг асфальт бетоноор хучих	80,000.00	79,422.30	Харьцуулалтын арга
10	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж болгох боломжгүй шороон хэсгүүдийг явган замын хавтангаар хучих	57,000.00	56,771.52	Харьцуулалтын арга

11	Улиастай сумын нийтийн эзэмшлийн газар болон орон сууцны гадаа хогийн сав байрлуулах	37,000.00	37,000.0	Харьцуулалтын арга
12	Богдын гол багт гэрэлтүүлэг нэмэгдүүлэх	100,000.00	98,270.67	Харьцуулалтын арга
13	Улиастай сумын төв тойргоос Генерал толгой хүртэлх 1600м газарт явган хүний зам шинээр байгуулах	200,000.00	198,222.25	Нээлттэй тендер шалгаруулалт
14	Аймаг үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулж, музейн үзүүлэн, дэглэлтийг шинэчилж Гүдэн цогцолборыг тохижуулах	70,000.00	69,743.09	Харьцуулалтын арга
15	Жавхлант толгойд тохижилтын ажил хийх	100,000.00	99,998.88	Харьцуулалтын арга
16	Цэргийн ангийн баруун талаас зүүн чиглэлийн пост хүртэлх явган замыг шинэчлэх	90,000.00	54,000.00	Харьцуулалтын арга
17	Улиастай сумын Богдын гол багийн "Хайрхан" дэлгүүрийн баруун уулзвараас БХТН-ийн гарц хүртэлх авто замын 2 талд явган хүний зам хийх	91,900.00	88,350.61	Харьцуулалтын арга
18	БХТН-ийн гарцаас 3-р сургуулийн урд гарц хүртэлх авто замын 2 талд явган хүний зам хийх	99,800.00	96,304.64	Харьцуулалтын арга
19	Улиастай сумын Богдын гол багийн 3-р сургуулийн урд гарцаас Төв цэнгэлдэх хүрээлэнгийн арын хашааны өнцөг хүртэлх авто замын 2 талд явган хүний зам хийх	95,400.00	94,564.66	Харьцуулалтын арга
20	Улиастай сумын Богдын гол багийн Төв цэнгэлдэх хүрээлэнгийн арын хашааны өнцгөөс "Ган доной" ХХК-ийн уурын зуух хүртэлх авто замын 2 талд явган хүний зам хийх	87,500.00	84,463.43	Харьцуулалтын арга
21	"Ган доной" ХХК-ийн уурын зуухнаас "Авто тээврийн төв" хүртэлх авто замын 2 талд явган хүний зам хийх	95,300.00	89,911.14	Харьцуулалтын арга
22	Богдын гол багийн таксины зогсоолыг бетондож засварлах	30,000.00	27,267.57	Харьцуулалтын арга
23	Богдын гол багийн модон гүүрний шалыг сэргээн засварлах	66,300.00	66,084.15	Харьцуулалтын арга
24	Хот тохижилт үйлчилгээний албанд зам цэвэрлэгээний тоногдсон автомашин авах	198,800.00	195,777.00	Нээлттэй тендер шалгаруулалт
25	Улиастай суманд нийтийн тээврийн автобус авах	120,000.00	108,185.00	Нээлттэй тендер шалгаруулалт
26	Улиастай сумын 6-н багийн нийтийн эзэмшлийн шороон замуудад шороо асгаж тэгшлэх	60,000.00	59,999.06	Харьцуулалтын арга

27	Хутагтын хүрээлэнгийн явган замын хавтан, хашлагыг шинэчлэх	37,000.00	36,969.46	Харьцуулалтын арга
28	Улиастай сумын Жинст багийн 20 айлын орон сууцны гадна талбайд авто зогсоол хийх	90,000.00	84,870.79	Харьцуулалтын арга
29	Улиастай сумын цахилгаан хангамжийг сайжруулах	50,000.00	49,841.85	Харьцуулалтын арга
30	Улиастай сумын Жинст багийн Завхан буудлын баруун талын зогсоол	60,000.00	17,000.00	Харьцуулалтын арга
31	Улиастай сумын Жинст багийн Холбооны 27-р байрны хойд хэсгийн зогсоол	60,000.00	58,127.83	Харьцуулалтын арга
32	Гудамж талбайн камержуулалт	80,000.00	79,868.32	Харьцуулалтын арга

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэл, сангийн сайдын тушаал, журамтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Оюунсүвд аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 3/46 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтийг нийт орлого 4,838,791.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 72,581.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 50,807.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй ч батлагдсан төсвийн хүрээнд зарлага гарган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор (shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим санд оруулсан байдлыг анхан шатны баримт, мөнгөн гүйлгээний журналтай тулган шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 396,810.9 мянган төгрөгийг мэдээлээгүй байна. Бусад мэдээллийг тухай бүр оруулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 19,692.9 мянган төгрөгийн зөрчилд 1 заалт зөвлөмж, 14,282.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлснийг тус тус 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	4	14,282.5	4	14,282.5	100
Зөвлөмж	1	5,410.4	1	5,410.4	100
Нийт дүн	5	19,692.9	5	19,692.9	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 135,895.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 135,895.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

Байгууллагад төлөх хүнсний материалын өр, төлбөрийн 5,000.0 мянган төгрөгийн санхүүгийн тайланд тусгаагүй, модны суулгац 13,210.0 мянган төгрөгөөр худалдан авсан ч бодитоор байхгүй бараа материалыг санхүүгийн тайланд авлагаар тусгасан, хандиваар ирсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр данс бүртгэлд тусгаагүй /программ, тээврийн хэрэгсэл-автобус/ 112,685.0 мянган төгрөг, худалдан авсан өвс тэжээлийг бараа материалын тайланд орлогод аваагүй 5,000.0 мянган төгрөгийн алдаа гаргасан байна. Энэ нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 дахь заалтууд, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 15 дугаар зүйлийн 15.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-тай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 179,819.4 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 53,993.6 мянган төгрөгийн төлбөрийн зөрчилд албан шаардлага, 125,000.8 мянган төгрөгийн зөвлөмж, 825.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

5.1 Төлбөрийн акт

Албан хаагчдад төсвөөс 825.0 мянган төгрөгөөр ажлын хувцас худалдан авсан байна.

5.2 Албан шаардлага

Төсвөөс Улиастай сумын 6 багийн ахмадуудын хүлээн авалт зохион байгуулж, гарын бэлэг, дурсгалын зүйлс, хоол хүнсний материал худалдан авсан зэрэг 53,993.6 мянган төгрөгийн зориулалт бус зардал гаргасан байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн татварын хэлтэс, Амь-Ус трейд ХХК-д үндэслэлгүй 5,915.8 мянган төгрөгийн өглөгийг шилжүүлсэн зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5, 7.1.3.21, мөн Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба

төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж, үндэслэлгүй өр төлбөр үүсгэхгүй байх;

2. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Эрх бүхий байгууллагын шийдвэргүй 119,085.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн зөрчил илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.3-д "Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох байгууллагын шийдвэргүйгээр үндсэн хөрөнгө бэлтгэдэг зөрчлийг арилгах;

3. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Газрын нэгдсэн системд бүртгэлтэй газрыг данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, УСНББОУС 31 Биет бус хөрөнгө АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 заалтууд болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны "Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.8-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын нэгдсэн системд бүртгэлтэй газруудыг данс бүртгэлд тусгах арга хэмжээг авч ажиллах;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 30-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Байгууллагад төлөх хүнсний материалын өр, төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй	1	5,000.00	1	5,000.00			1	5,000.00	0	0		
Модны суулгацыг санхүүгийн тайланд аялгаар тусгаагүй	1	13,210.00	1	13,210.00			1	13,210.00				
ОНХС-н хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг үнэ төлбөргүй хөрөнгөөр данс бүртгэлд тусгаагүй /программ, тээврийн хэрэгсэл-автобус/	1	112,685.00	1	112,685.00			1	112,685.00				
Худалдан авсан өвс тэжээлийг бараа материалын тайланд орлогод аваагүй	1	5,000.00		-	1	5,000.00	1	5,000.00				
Дүн	4	135,895.00	3	130,895.00	1	5,000.00	4	135,895.00	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шөврдлага		Хууль хяналтын байгууллагад шийгжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Газрын нэгдсэн системд бүртгэлтэй газрыг данс бүртгэлд тусгаагүй	1	0			0	-	1	-				
Аймгийн татаварын хэлтэс, Амь-Ус ХОХ-д үндэслэлгүй өглөгийг шилжүүлсэн	1	5,915.80			0	-	1	5,915.80				
Эрх бүхий байгууллагын шийдвэргүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн	1	119,085.00			0	-	1	119,085.00				
Улиастай сумын 8 багийн ахмадуудыг хүлээн авч гарын бэлэг дурсгалын зүйл гардуулж, хоол хүнсний материал худалдан авч зориулалт бус зардал гаргасан	1	53,993.60			1	53,993.60	0	-				
Аж ахуйн албан хаагч нарт ажлын хувцас худалдан авч өгсөн /жолооч нарт/	1	825.00	1	825.00			0	-				
Дүн	5	179,819.40	1	825.00	1.00	53,993.60	3	125,000.80	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.БАТ-УНДРАА
Х.БОЛДБААТАР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Г.БААСАНЖАРГАЛ

2024.02.23